



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/194

Улаанбаатар хот

Г Дүрэм батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.“Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг нэгдүгээр, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 2.Дүрмийг алба хаагчдаар судлуулж, үйл ажиллагаандaa мөрдүүлж ажиллахыг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
- 3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (цагдаагийн хурандаа Т.Ганзориг)-д даалгасугай.
- 4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/201 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
- 5.Тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Т.СҮХБОЛД



Цагдаагийн өрөнхий газрын даргын
2024 оны 05 дугаар сарын 00-ны
өдрийн 00 дугаар тушаалтын
0 дүгээр хавсралт



ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилт нь цагдаагийн албаны үнэт зүйл¹, алба хаагчийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээ, шаардлагыг тодорхойлж, гэмт хэрэг, зөрчил, сахилга, ёс зүйн зөрчил үйлдэхээс сэргийлэх, хяналт тавих, ёс зүйн хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм нь Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актад тусгагдсан хэм хэмжээ, энэхүү дүрмээс бүрдэнэ.

1.3. Энэ дүрмийг цагдаагийн алба хаагч нь үйл ажиллагаандаа мөрдлөг болгон албаны нэр хүнд, алба хаагчийн ёс зүйг эрхэмлэн дээдэлж, сахин биелүүлнэ.

1.4. Цагдаагийн алба хаагч Төрийн албаны тухай, Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай, Цагдаагийн албаны тухай хуульд заасан зарчмаас гадна дараах ёс зүйн зарчмыг баримтална:

- 1.4.1. хууль дээдлэх;
- 1.4.2. шударга байх;
- 1.4.3. хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ялгavarлан гадуурхахгүй байх;
- 1.4.4. хариуцлагатай байх;
- 1.4.5. манлайлах, хамтаж байх.

1.5. Энэ дүрэм нь Цагдаагийн албаны тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан дадлагажих ажилтанд нэгэн адил хамаарна.

Хоёр. Ёс зүйн хэм хэмжээ

2.1. Хууль дээдлэх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

2.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний акт, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, дээд шатны байгууллага, албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг ёсчлон биелүүлж, захирах, захирагдах ёсны зарчмыг баримтлах;

2.1.2. цагдаагийн байгууллагын нэр хүнд, олон нийтийн итгэл нь алба хаагч нэг бүрээс шууд шалтгаална гэдгийг байнга анхаарч, албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

2.1.3. төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг буюу хувийн мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бусдад санаатай эсхүл болгоомжгүйгээр задруулах, удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан

¹ www.police.gov Цагдаагийн байгууллагын үнэт зүйл "Эх орон, ард иргэддээ өргөсөн тангараг"

ажлын мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэхгүй байх;

2.1.4.албан ажилд шаардлагатай мэдээллийг нуун дарагдуулахгүй байх, удирдлагыг шийдвэр гаргахад бодитой, хуульд нийцсэн, үнэн зөв мэдээллээр шуурхай хангах.

2.2.Шударга ёсны зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

2.2.1.алба хаагч нь хувийн болон нийгмийн амьдралдаа нэр төртэй, үнэнч, зарчимч, хүндлэл төрүүлэхүйц байдлыг эрхэмлэж байх;

2.2.2.алба хаагч нь албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, өөртөө болон бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдэд эдийн болон эдийн бус ашигтай байдал бий болгох хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг гаргахгүй байх;

2.2.3.хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлэн ашигласан аливаа үйлдэлтэй эвлэрэхгүй байж, энэ талаар хамтран ажиллаж байгаа алба хаагчид хууль ёсны шаардлага тавих, удирдах албан тушаалтанд мэдэгдэх;

2.2.4.алба хаагч мэдээ, мэдээлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, гэмт хэрэг, зөрчлийг шалгаж байх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, эсхүл үүсэж болзошгүй нөхцөлд гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, шууд удирдах албан тушаалтанд бичгээр мэдэгдэх;

2.2.5.улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс анgid байж, тэдгээрийн зохион байгуулсан үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцох, бусдыг татан оролцуулах, оролцох санал тавихгүй байх;

2.2.6.шалгаж байгаа өргөдөл, гомдол, хэрэг, маргааны оролцогчтой хувийн харьцаа тогтоохгүй байх;

2.2.7.хамтран ажиллаж байгаа алба хаагч, байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, хөндлөнгөөс хууль бусаар нөлөөлөхгүй, харьяаллын бус хэрэг, маргаанд оролцохгүй байх.

2.3.Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

2.3.1.бусдыг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн байдал, гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхахыг цээрлэх;

2.3.2.хүний нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэж, бусдад эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандахгүй байх;

2.3.3.хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусадтай зөв боловсон эелдэг, хүлээцтэй, тэвчээртэй, ажил хэрэгч, зарчимч харьцах бөгөөд бусдын эрхэнд хууль бусаар халдах, өөрийн байр суурийг бусдад тулгах, доромжлох, далайлган сүрдүүлэх, чирэгдүүлэх, хүнд суртал гаргах, бусдыг үл тоомсорлох, хууран мэхлэх зэрэг аливаа зохисгүй үг, үйлдэл гаргахгүй байх;

2.3.4.удирдах албан тушаалтан, алба хаагч, ажилтан нь бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлэх, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироо үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх зэрэг үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;

2.3.5.гэмт хэрэг, зөрчил болон золгүй тохиолдлоос хохирсон, биеэ хамгаалж чадахгүй, амь нас, эрүүл мэндэд нь ноцтой аюул учирч болзошгүй иргэнд хүнлэг энэрэнгүй хандаж, боломжит дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг эрмэлзэх, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж яаралтай үзүүлэх арга хэмжээ авах.

2.4.Хариуцлагатай байх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

2.4.1.цагдаагийн алба хаагч байгууллагын нэр төр, алдар хүнд, иргэдийн итгэлд харшлах аливаа үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байж, зан харилцаа, ёс суртахууны хувьд өндөр төлөвшилтэй байх;

2.4.2.хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аливаа асуудалд нухацтай хандаж, өөртөө өндөр шаардлага тавьж, эрсдэл гаргахаас урьдчилан сэргийлэх;

2.4.3.хууль тогтоомжид заасан албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх талаар байнгын хичээл зүтгэл гаргаж, өөрийн алдаа, дутагдлыг арилгахыг эрмэлзэх;

2.4.4.албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс, жаягийг чанд баримтлах, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;

2.4.5.байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа аливаа үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх, энэ төрлийн арга хэмжээг зохион байгуулж, оролцохгүй байх;

2.4.6.мөрийтэй, бооцоот тоглоом болон хуулиар хориглосон тоглоом тоглох, зохион байгуулахад оролцохгүй байх;

2.4.7.ажлын байранд, ажлын цагаар, эсхүл албан үүрэг гүйцэтгэж явахдаа болон цагдаагийн дүрэмт хувцастай байхдаа согтууруулах ундаа хэрэглэхгүй, хуулиар хориглосон газарт утаат тамхи татахгүй байх, олон нийтийн газарт нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг сахиж, албандаа хүндэтгэлтэй хандах;

2.4.8.хуулиар хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхгүй байх;

2.4.9.согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх;

2.4.10.гэр бүлийн гишүүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие маходод халдахгүй байж, нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээг сахиж мөрдөх;

2.4.11.олон нийтийн цахим сүлжээ, мэдээллийн сувгуудад зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд албаны мэдээ, мэдээлэл оруулахгүй байх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцахдаа төвийг сахисан байдлыг хангаж, хувийн итгэл үнэмшил, үзэл бодлоо илэрхийлэхээс зайлсхийх, үзэл бодлоо илэрхийлэх, уг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, эрх, эрх чөлөөгөө өдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандах;

2.4.12.цагдаагийн дүрэмт хувцас, албаны үнэмлэх, тэмдэг, тусгай болон техник хэрэгслийг бусдад дамжуулах, хэрэглүүлэх, бусдад барьцаа болгон үлдээхгүй, хаяж үрэгдүүлэхгүй, хууль бусаар хэрэглэх, албаны нэрийг хувийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

2.4.13.өөрийн шийдвэр, үйл ажиллагааны үр дагаврыг бүрэн хариуцаж, албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээх.

2.5. Манлайлах, хамтас байх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрднө:

2.5.1. байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан, олон нийтийн итгэлийг алдагдуулахуйц аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтийн дунд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх;

2.5.2. багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах;

2.5.3. удирдах албан тушаалтан бусдын ажил хэрэгч саналыг хүлээн авч шийдвэрлэн, ёс зүйн хувьд бусдад үлгэр дуурайлал үзүүлж байх;

2.5.4. бусдын ажил хэрэгч саналыг үл хайхрах, мушгин гүйвуулахгүй байх, худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;

2.5.5. удирдлагын зохих шийдвэргүй, хүндэтгэн үзэх шалтгаангүй ажил таслах, ажлын байр, хариуцсан ажил, үүргээ дур мэдэн орхих, хууль, журмын хүрээнд өгөгдсөн үүрэг, даалгавар, шаардлагыг хууль бусаар эсэргүүцэхгүй байх;

Гурав. Хариуцлага

3.1. Цагдаагийн алба хаагчийг ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг албан тушаал, цол, ажилласан жилийг үл харгалзан шалгаж шийдвэрлэнэ.

3.2. Ёс зүйн зөрчил гаргасан цагдаагийн алба хаагчид эрх бүхий албан тушаалтан Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан, дэс дараалан хэрэглэхгүйгээр оногдуулна.

3.3. Ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн алба хаагчийг Цагдаагийн албаны тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1-д заасны дагуу албанаас хална.

Тайлбар: “Ноцтой зөрчил” гэж Цагдаагийн албаны тухай хуульд заасан цагдаагийн алба хаагчийн хориглох зүйлийг зөрчсөн буюу бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх үр дагавар бий болгосон, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа өнгөрөөгүй байхад 2 буюу түүнээс дээш удаа үйлдсэн үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

3.4. Ёс зүй зөрчсөн алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулахтай холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомж болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаар зохицуулна.

Дөрөв. Бусад

4.1. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд цагдаагийн төв, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нар өдөр тутам хяналт тавьж ажиллах үүрэгтэй бөгөөд алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.

4.2. Удирдах албан тушаалтан хариуцсан байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрдээлийг тооцох, арилгах, бууруулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол авна.

4.3. Ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж байгаа нь алба хаагчийг шагнаж, урамшуулах, өөр албан тушаалд дэвшүүлэх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, албан тушаал бууруулах үндэслэл болох бөгөөд ёс зүйн хувьд бусдад үлгэр дуурайлал үзүүлсэн, иргэд, байгууллагын талархал хүлээсэн алба хаагчийг дараах байдлаар урамшуулж болно:

- 4.3.1.хамт олны өмнө сайшааж хувийн хэрэгт тэмдэглэх;
- 4.3.2.цалинг үр дүнгээр нэмэх (тэтгэмж, мөнгөн урамшуулал олгох);
- 4.3.3.боловсрол мэдлэгээ дээшлүүлэх, сургалтад хамрагдах эрх олгох;
- 4.3.4.цалинтай амралт, сувилалд хамруулах;
- 4.3.5.цагдаагийн байгууллагын болон салбарын шагналд шагнуулахаар тодорхойлох;
- 4.3.6.албан тушаал дэвшүүлэх саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах.

---oOo---

Цагдаагийн ерөнхий газрын даргын
2024 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын
... дугаар хавсралт

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН САХИЛГЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дурмийн зорилго нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, цагдаагийн албаны хэвийн үйл ажиллагаа, захирах, захирагдах ёс, хүний эрхийт хангах, алба хаагчийн баримтлах сахилгын хэм хэмжээг тогтоох, хариуцлагыг журамлан зохицуулах замаар тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

1.2. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм (цаашид “Дүрэм” гэх) нь цагдаагийн алба хаагчдад тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлно.

1.3. Алба хаагчийг Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, цагдаагийн алба хаагчийн тангараг, ёс зүй, сахилгын дүрмийг сахин биелүүлэхийг шаардана.

1.4. Цагдаагийн албаны тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан дадлагажих ажилтан энэ дүрмийг нэгэн адил баримтална.

1.5. Энэ дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1. “цагдаагийн алба хаагчийн сахилга” гэж Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, цагдаагийн алба хаагчийн тангарагаар хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлэхийг;

1.5.2. “сахилгын зөрчил” гэж холбогдох хууль тогтоомж, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;

1.6. Цагдаагийн алба хаагчийн сахилга нь хууль тогтоомж, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг сахин биелүүлснээр хангагдана.

1.7. Цагдаагийн алба хаагч өргөсөн тангарагтаа үнэнч байж, түүнийг ёсчлон биелүүлж, ёс зүй, сахилгын дүрмийг сахин биелүүлэх үүрэгтэй.

1.8. Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтан сахилга, дэг журмыг бэхжүүлэх, алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй, алба хаагчдад буруу үлгэр дуурайлал үзүүлж, албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн бусдыг аливаа хэлбэрээр хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах, түүнчлэн ажлын байрны болон бэлгийн дарамт үзүүлэх, хууль бус тушаал, шийдвэр биелүүлэхийг шаардсан нь сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.

Хоёр. Сахин баримтлах хэм хэмжээ

2.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээний цагдаагийн үйл ажиллагаанд холбогдох заалт, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн

1979 онд баталсан Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль, Интерполоос баталсан дүрэм, журам, Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Цагдаагийн тангараг, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн төв байгууллагаас тогтоосон цагдаагийн байгууллагын хөдөлмөрийн дотоод буюу үйл ажиллагааны журам, энэ дүрмийг алба хаагч бүр дагаж мөрдөнө.

Гурав.Сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл

3.1.Цагдаагийн алба хаагчид дараах үндэслэлээр сахилгын шийтгэл оногдуулна.

3.1.1.Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, ёс зүйн болон энэ дүрмийг зөрчсөн;

3.1.2.цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам зөрчсөн

3.1.3.удирдах албан тушаалтнаас өгсөн хуульд нийцсэн тушаал, үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй;

3.1.4.байгууллагын дотоод дүрэм, журам зөрчсөн;

3.1.5.хуульд заасан албаны чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй;

3.1.6.цагдаагийн алба хаагчийн ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадвараас шалтгаалсан алдаанаас хууль тогтоомж зөрчигдсөн нь тогтоогдсон.

3.2.Сахилгын шийтгэл оногдуулах тохиолдолд алба хаагчаас сахилгын зөрчил гаргасан байдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд албаны шалгалт явуулж, үндэслэл бүхий баримт нотломжоор тогтоосон байна.

Дөрөв.Сахилгын дүрэм зөрчсөн алба хаагчид хүлээлгэх хариуцлага

4.1.Энэ дүрэмд заасан сахилгын хэм хэмжээг зөрчсөн нь тухайн алба хаагчид Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага ногдуулах үндэслэл болно.

4.2.Цагдаагийн алба хаагчийн ажлын бус цагаар сахилга, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйд сахилгын шийтгэл оногдуулахдаа шууд удирдах албан тушаалтанд үндэслэлгүйгээр хариуцлага хүлээлгэхийг хориглоно.

4.3.Сахилгын зөрчил гаргасан цагдаагийн алба хаагчид эрх бүхий албан тушаалтан Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан, дэс дараалан хэрэглэхгүйгээр оногдуулна.

4.4.Цагдаагийн алба хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэхтэй холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомж болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаар зохицуулна.